



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 8/15

Шивээговь сум

Д.Сувд-Эрдэнийг багийн Засаг даргаар
 томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6, 57 дугаар зүйлийн 57.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, сумын 1 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлаас 1 дүгээр багийн Засаг даргын албан тушаалд нэрийг нь дэвшүүлсэн Дэндэвийн Сувд-Эрдэнийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн багийн Засаг даргаар томилсугай.

2. Д.Сувд-Эрдэнийн албан тушаалын үндсэн цалинг 603,031 (зургаан зуун гурван мянга гучин нэг) төгрөгөөр тогтоож, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30%-иар бодож олгохыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3. Д.Сувд-Эрдэнэд үүрэгт ажлыг хүлээлцэхэд шаардагдах бичиг баримт, эд хөрөнгийн жагсаалтыг гарган, хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Мөнхцэцэг

(Нярав)

Б.Ууганбаяр

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

421220189

4.Ажлыг чанартай хугацаанд нь зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Ц.Цэрэндорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ